



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027

И-мэйл: info@fchm.edu.mn

2024. 11. 29 № 11875
танай —ны № —т

Г ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН
АЛБАНД

Г Тайлан хүргүүлэх тухай

2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1216 тоот албан бичгийн дагуу дэд зөвлөлийн баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 8 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ХҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

003192

**УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН ТАЙЛАН**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хамтран ажиллах байгууллага
ЗОРИЛТ 1. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД					
1	Эрүүл мэндийн байгууллагуудад хөдөлмөрийн тухай хуулийн 144.2, 144.4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах	I-IV улирал	Ажилд шинээр авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авсан эрүүл мэндийн байгууллагын тоо	ХБИ-дэд дэмжлэг үзүүлсэн байна.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэгт 2024 оны 11 сарын байдлаар нийт 20 хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллаж байна. Эмэгтэй 15 ажилтан, эрэгтэй 5 ажилтан байна.

Үүнээс:

- Сонсох бэрхшээлтэй - 3,
- харах бэрхшээлтэй - 2,
- Тулах, хөдлөх эрхтний-3
- Бусад бэрхшээлтэй - 12 ажилтан байна.
- Албан тушаалаар задалбал удирдах албан тушаалтан - 2, их эмч - 3, сувилагч тусгай мэргэжилтэн - 13, бусад ажилтан - 2 байна.


ДД	Нас	Хүйс	Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Хөгжлийн бэрхшээлийн төрөл
1.	52	эм	Харданы	терөлхийн
2.	33	эм	Харданы	терөлхийн
3.	49	эм	Тулах, хөдлөх эрхтний	терөлхийн
4.	42	эм	Тулах, хөдлөх эрхтний	олдмоп
5.	25	эм	Тулах, хөдлөх эрхтний	терөлхийн
6.	50	эм	Сонсгол	олдмоп
7.	30	эр	Сонсгол	терөлхийн
8.	55	эм	Сонсгол	терөлхийн
9.	60	эр	бусад	олдмоп
10.	45	эр	бусад	олдмоп
11.	52	эм	бусад	олдмоп
12.	51	эм	бусад	олдмоп
13.	57	эм	бусад	олдмоп
14.	52	эм	бусад	олдмоп
15.	51	эм	бусад	олдмоп
16.	29	эр	бусад	олдмоп
17.	43	эм	бусад	олдмоп
18.	36	эм	бусад	терөлхийн
19.	47	эм	бусад	олдмоп
20.	47	эм	бусад	олдмоп

Хүснэгт 1. УНТЭ-т ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын чадвар алдалтын мэдээлэл

Мөн байнгын асаргаа шаардсан хүнд эмгэгтэй хүүхэд болон эцэг эхтэй 49 ажилтан ажиллаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль

болон Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 10.11 дэх заалтын дагуу байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асрах шаардлагатай 3 ажилтны хүсэлтийг шийдвэрлэж, ажил тарах цагаас 1 цагийг богиносгон ажиллуулж байна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2024 оны 08 сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан нуугдмал баялаг төслийн уулзалт, эзэрэг нөлөөлийн арга хэмжээ, хэлэлцүүлэгт НЭМА-ны дарга З.Ариунжаргал оролцсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэхэд тулгардаг асуудлын алаар байр сууриа илэрхийлж хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж оролцсон.




Зураг 1. Уулзалт, хэлэлцүүлгийн явцаас

2	Салбарын бүх шатны байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээг хийж, 30-аас доошгүй хувийг нь хүртээмжтэй болгох	I-IV улирал	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээг хийсэн байгууллагын тоо	30-аас доошгүй хувь	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
---	--	-------------	--	---------------------	-------------------------------------

УНТЭ-ийн амбулаторийн хэсэгт “Амбулаторийн үйл ажиллагааны түр журам”-ын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд” тусlamж үйлчилгээ, оношлогоо, эмчилгээ үзүүлэхдээ биеийн байдал хүнд, өөртөө үйлчлэх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийг эрэмблэн ангилалт хийж, тэргэнцэрээр үйлчилж, шуурхай байдлыг хангаж ажиллаж байна. Амбулаториор үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн цус харвалтын дараах саа саажилтай, өндөр настай явж чадахгүй, мэс заслын дараах байдалтай үйлчлүүлэгчдэд 15 тэргэнцэрээр үйлчилгээ үзүүлж байна. Харуулын албатай хамтран эвдэрсэн 10 тэргэнцрийг засч сэлбэж аюулгүй байдлыг ханган үйлчилгээнд гаргасан болно. Шинээр 4 тэргэнцрийн хангалтыг хийлгэж чек листээр бүрэн бүтэн аюулгүй байдлыг ханган үйлчилгээг үзүүлж байна. Өдөр бүр тэргэнцрийн бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааг шалган хяналтын хуудсаар хяналт тавьж үйлчилгээнд гарган ажилладаг.



Зураг 2: Тэргэнцирийг ил байрлуулсан бөгөөд тус бүр дээр даацийн мэдээлэл байршуулсан



Зураг 3: Шатны хажууд бариул хийсэн байдал



Зураг 4: Тэргэнцэртэй үйлчлүүлэгчдэд зориулсан налуу зам

Амбулаториор үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэн ариун цэврийн өрөөг 2-4 давхар тус бүрт гарын доорхи материал ашиглан тохижуулж үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.



Зураг 5. Гарын доорх материал орны толгой ашиглаж хийсэн байдал

УНТЭ нь Нано интернэйшнл ХХК-тай хамтран иргэд, олон нийтэд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, эмнэлгийн сувилахуйн тусlamж үйлчилгээний ажилтнуудад асаргаа сувилгааны талаарх шинэ мэдээллийг хүргэх, мэдээлэл, сургалт зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулсан бөгөөд уг санамж бичгийн хүрээнд эмнэлгийн амбулаторын хэсгийн 1 ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэхэд тохирсон стандарт бүхий бүрэн тоноглооор тохиролцсон бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгөөг боловсруулж байна.

3	Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал /ICF/-ыг нэвтрүүлэх сургалт зохион байгуулах	I-IV улирал	Зохион байгуулагдсан сургалтын тоо	Сургалт зохион байгуулагдсан байна.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
---	---	-------------	------------------------------------	-------------------------------------	-------------------------------------

Сэргээн засах тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг (2021-2026) хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал”-ыг (ICF) танилцуулах, талуудын уулзалт” сэдэвт сургалтыг ЭМЯ-наас 2023 оны 12 сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Уг сургалтанд НЭМА-ны дарга З.Ариунжаргал хамрагдсан ба сургалтаар олж авсан мэдлэгээ хамт олондоо түгээж мөн “Үйлдлийн олон улсын ангилал” (ICF)-ыг нэвтрүүлэх зорилгоор СЗЭТ, УЭТ -ийн тасгийн эрхлэгч Б.Анхбаяр эмчтэй хамтран төлөвлөгөө боловсруулан , ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж II-III улиралд ICF-ийн талаарх сургалтыг өөрийн байгууллагадаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



Зураг 6. Сургалтын явцаас

УНТЭ-ийн СЗЭТасаг нь Бие Бялдар Сэргээн Засах Судлалын Монголын Нийгэмлэгтэй хамтран сэргээн засахын эмч нарыг яс булчингийн хэт авиан шинжилгээг хийх талаар анхан шатны мэдлэгтэй болгох, ур чадварыг эзэмшүүлэх, эмнэлзүйн практикийн хэрэглээг

нэмэгдүүлэх зорилгоор “Яс булчингийн хэт авиан шинжилгээний баримжаа олгох” багц цагийн сургалтыг 2024 оны 06-р сарын 15, 22, 29-ний өдрүүдэд УНТЭ-ийн Сэргээн засах эмчилгээний тасагт зохион байгуулсан.

Тус сургалтад АШУҮИС-ийн АҮС-ийн Радиологийн тэнхимийн багш, Тэргүүлэх зэргийн эмч П.Төгсжаргал, Сэргээн засах судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Тэргүүлэх зэргийн эмч Ж.Соёлмаа, УНТЭ-ийн Радиологийн тасгийн эмч Б.Эрдэнэцэцэг эмч онолын хичээл зааж , нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүд дадлагын хичээлд чиглүүлэгч эмчээр ажилласан бөгөөд сургалтанд нийтдээ сэргээн засах эмчилгээний 18 эмч мэргэжилтэн хамрагдсан.



Зураг 7. Сургалтын явцаас

ЗОРИЛТ 2.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ, ОРОЛЦОО, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ

4	Тархи, нуруу, нугасны гэмтлийн улмаас хөдөлгөөний болон өдөр тутмын үйл ажиллагааны чадвар алдагдсан, нийгмийн оролцоо хязгаарлагдсан иргэдэд эмнэлгийн болон нийгмийн сэргээн засах тусlamж үйлчилгээ үзүүлтэл дэмжлэг үзүүлэх	I-IV улирал	Холголт, цооролтыг урт хугацаанд бүрэн эмчлүүлэх нөхцөл бүрдсэн байх	Холголт цооролттой хүмүүст үзүүлэх тусlamж, үйлчилгээний сайжирсан байна.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
---	---	-------------	--	---	-------------------------------------


УНТЭ-ийн мэдрэлийн эмнэлзүйн төв нь мэдрэлийн эмгэг болон харвалтын нэгж гэсэн эмчийн болон сувилахуйн 2 багтайгаар үйл ажиллагаа явуулж хурц харвалтын дараах болон харвалтын эмгэгтэй үйлчлүүлэгч нарт тусlamж үйлчилгээ үзүүлдэг. Үйлчлүүлэгч нарыг

харвалтын дараах хөдөлгөөний бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлж тасагт хүлээн авч эмчлүүлсэн өдрөөс эхлэн эмнэлгээс гарах хүртэл сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр саатай гар хөлд булчингийн хүч сайжруулах, байрлал солих, угаалга хийх, амны хөндий цэвэрлэх асаргаа сувилгааг хийх, харвалтын үеийн асаргаа сувилгаанд ашиглагдаж байгаа туслах материалыг зөв ашиглах, хэрэглэх зэрэг зөвлөмжийг өвчний онцлогт тохируулан ажилладаг бөгөөд 2024 онд хэвтэн эмчлүүлсэн 61 эмчлүүлэгчийн ар гэрт дээрх зөвлөмжийг өгч ажилласан. Мөн МЭТ-д хэвтэн эмчлүүлж буй тархины харвалтаас үүдэлтэй үйл ажиллагааны чадвар алдагдалтай үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлийн гишүүдэд сэргээн засах эмчилгээний стандарт удирдамжийн дагуу СЗЭТ, УЭТ-ийн хөдөлгөөн засалч мэргэжилтнүүд сэргээн заслын тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Хөдөлгөөн засалчид нь тухайн хүнд үнэлгээ хийсний дагуу өөрт тохиорох хөдөлгөөн заслын эмчилгээг үзүүлэн ажилладаг бөгөөд 2024 оны эхний хагас жилд тархины харвалт болон нурууны мэс заслын улмаас өдөр тутмын хөдөлгөөний чадвар алдагдсан 61 гаруй үйлчлүүлэгчид тохиорох хөдөлгөөн заслын эмчилгээг үзүүлсэн байна.



Зураг 8. Эмчилгээний явцаас

2. УНТЭ нь байгууллагын гадаад цахим хуудсанд байрладаг Зөвлөгөө мэдээллийн булангаараа дамжуулан МЭТ-ийн сувилахуйн баг “Сувилагч зөвлөж байна” булангаар “Хэвтрийн өвчтөний асаргаа сувилгаа” сэдвээр 4 минутын видео контентийг бэлтгэн байршуулсан бөгөөд хандалтын тоо 9000 үзүүлэлттэй байна.



Зураг 7. Сувилагч зөвлөж байна булангийн явцаас

3. УНТЭ-ийн СЗЭТ-ийн хөдөлгөөн засалч Г.Туул нь 2024.05.15 өдөр Монгол HD телевизын “Өнөө өглөө” хетэлбөрт “Тархины цус харвалтын дараах хөдөлгөөн заслын эмчилгээний ач холбогдол” сэдвээр зөвлөгөө мэдээлэл өгч хөдөлгөөн засах дасгал хөдөлгөө зааж өгч ажилласан.



Зураг 8. Ярилцлагын явцаас

5	Эрүүл мэндийн байгууллагуудад дохионы хэлмэрчийг ажиллуулах, Сонсголгүй иргэдийг дэмжих чиглэлээр байгууллагуудтай хамтран ажиллах	I-IV улирал	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Эрүүл мэндийн байгууллага бүр дохионы хэлмэрчтэй болсон байна.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
---	--	-------------	------------------------------------	--	-------------------------------------

УНТЭ-ийн амбулаторийн хэсэгт нийт 4 ажилтан дохионы хэлний анхан шатны харилцааны аргазүйн сургалтанд хамрагдсан бөгөөд 2024 онд мэдлэг сэргээх сургалтанд дахин хамрагдсан.



Зураг 9. Дохионы хэлний багш, докторант Б.Саранчимэг багшийн сургалтанд хамрагдаж бэлтгэгдсэн ажилчид

Тайлан хянасан: НЭМА-ны дарга

4808

Г.Алтанцоо

Тайлан боловсруулсан: НЭМА-ны мэргэжилтэн



Д.Гандулам